



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/126

Шивээговь сум

Ажлын гүйцэтгэлийг хүлээж авах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны халаалтын шугамыг шинэчлэх /подволд халаалтын шугамыг хэсэгчлэн сольж узель хийх/ гадна шугамыг засварлах” ажлын гүйцэтгэлийг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

Ш.Чинболд

(Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын захирал)

Хөндлөнгийн төлөөлөл:

Б.Дэлгэрдалай

(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Эрдэнэ

(“Тохилог сууц” сууц өмчлөгчдийн  
холбооны дарга)

2. Хүлээн авсан “Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны халаалтын шугамыг шинэчлэх /подволд халаалтын шугамыг хэсэгчлэн сольж узель хийх/ гадна шугамыг засварлах” ажлыг байгууллагын хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын захирал (Ш.Чинболд)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлага хангасан засварын ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан акт үйлдэж, холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ